



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/22.

Номгон

“Иргэд ба халдвар хамгаалал-2” нэгдсэн арга  
хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 зүйлийн 27<sup>1</sup>.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2020 оны А/790 дүгээр захирамж, аймгийн Онцгой комиссын “Төв шуурхай штаб”-ын 2022 оны 13/01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн хэмжээнд коронавирусын халдвар тархах эрсдэл өндөр байгаатай холбогдуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг баримтлах, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Иргэд ба халдвар хамгаалал-2” нэгдсэн арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2.“Иргэд ба халдвар хамгаалал-2” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, байгууллагуудын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601220049

Аймгийн Засаг даргын ..... оны.....дүгээр  
сарын ....-ны өдрийн ..... захирамжийн  
1 дүгээр хавсралт

**“ИРГЭД БА ХАЛДВАР ХАМГААЛАЛ-2” НЭГДСЭН АРГА  
ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

1.1. Аймгийн Засаг даргын 2020 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тухай сунгах тухай” А/790 дүгээр захирамж, аймгийн Онцгой комиссын “Төв шуурхай штаб”-ын 2022 оны 13/01 дүгээр хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангах, коронавирусын халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор хүн, ам цугларч олноор үйлчлүүлдэг зах, худалдааны төв болон иргэдэд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хүн, амын хэт бөөгнөрөл үүсгэхгүй байх арга хэмжээг нэгдсэн хэлбэрээр зохион байгуулахад оршино.

**Хоёр. Хамрах хүрээ, зохион байгуулах арга хэмжээ**

2.1. Тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зах худалдааны төвүүдээр үйлчлүүлж байгаа иргэд олон нийтэд амны хаалт болон халдвар хамгааллын дэглэм, хүн хоорондын зай хэмжээг баримтлуулж, урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгч, тогтоол, шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар иргэдийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.

**Гурав. Хамтран зохион байгуулах ажлын хэсэг**

3.1. Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, сумдын Засаг даргын Тамгын газрууд хамтран зохион байгуулна.

**Дөрөв. Хугацаа**

4.1. “Иргэд ба халдвар хамгаалал-2” нэгдсэн арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд 1 сарын хугацаанд зохион байгуулна.

**Тав. Дүгнэх**

5.1. “Иргэд ба халдвар хамгаалал-2” нэгдсэн арга хэмжээний дүнг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр дээрх арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцож, аймгийн Онцгой комиссын хуралдаанд дүнг танилцуулна.

-----oOo-----

Аймгийн Засаг даргын ....оны.... дүгээр сарын  
 .....-ны өдрийн ... захирамжийн .....дугаар  
 хавсралт

**“ИРГЭД БА ХАЛДВАР ХАМГААЛАЛ-2” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ  
 ЗОХИОН БАЙГУУЛАХ, БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ**

Д/д	Худалдаа үйлчилгээний газрууд	Хамран зохион байгуулах	Хариуцах байгууллага албан тушаалтан
1	Баруун бүс худалдааны төв	Онцгой байдлын газар 2, Цагдаагийн газар 2, Мэргэжлийн хяналтын газар 1, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 4 алба хаагч	Цагдаагийн газар Цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөтулга 89001400
2	Баруун бүс 2		
3	Есөн-Эрдэнэ зах	Онцгой байдлын газар 2, Цагдаагийн газар 2, Мэргэжлийн хяналтын газар 2, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 4 алба хаагч	Мэргэжлийн хяналтын газар Ууганбаяр 89009189
4	Шаргалжуут	Онцгой байдлын газар 1, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар 1 алба хаагч	Онцгой байдлын газар ахмад Х.Цэнд-Очир 88044339
5	Анурад	Цагдаагийн газар 1, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар 1 алба хаагч	Цагдаагийн газар Цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөтулга 89001400
6	Шөнийн зах худалдааны төв	Онцгой байдлын газар 1, Цагдаагийн газар 1, Мэргэжлийн хяналтын газар 1	Цагдаагийн газар Цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөтулга 89001400
7	Номгон хаан		
8	Мэргэн 2		
9	“Буянт богд” ХХК	Онцгой байдлын газар 1, Цагдаагийн газар 1, Мэргэжлийн хяналтын газар 1 Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар 1 алба хаагч	Мэргэжлийн хяналтын газар Б.Ууганбаяр 89009189
10	Шар бүрд	Онцгой байдлын газар 1, Цагдаагийн газар 1, Мэргэжлийн хяналтын газар 1 Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар 2 алба хаагч	Мэргэжлийн хяналтын газар Ууганбаяр 89009189
11	Амар		
12	Тайхар		
13	Накула		
14	Их Номгон 1		
15	Их Номгон 2		
16	Титэм		
17	Жинжин		
18	Сумдад	Сумын ЗДТГ-1, ЦГ-1, Иргэд-1	Сумын ЗДТГ-ын дарга

Жич:

1.Өдөр бүр Онцгой байдлын газраас 7 алба хаагч, Цагдаагийн газраас 8 алба хаагч, Мэргэжлийн хяналтын газраас 6 алба хаагч, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газраас 13 алба хаагч ийг томилгоожуулан 1 сарын хугацаанд ажиллана.

2.Иргэдэд ухуулга сурталчилгаа хийх, халдвар хамгааллын дэглэмийг баримтлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

-----oOo-----